

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ
“МОНГОЛ СУДЛАЛ”

Эрдэм шинжилгээний сэтгүүл

Боть XLVII (597)

DOI: 10.22353/ms20234732

Александр ба Түрэгүүд^{1,2}

John Andrew Boyle (Manchester)

Орчуулсан: Ц.Отгонсүрэн
Хянан зөвлөсөн: Боржигин Отгон

Энэтхэгийн гайхамшгуудын талаар Аристотелд бичсэн захидлын үргэлжлэл болгож, Төв Ази болон Хятад улсаар хийсэн түүний аяллын талаарх нэгэн тодорхой тайлбарыг Александрын Туужийн сири хувилбарт хийсэн юм³.

Александр “Прасиакийн улс (the country of Prasiake)” буюу Магадагийн хаант

¹ БНХАУ, Баруун Хойтын Үндэстний Их Сургуулийн Нийгмийн Шинжлэх Ухааны Сургуулийн профессор Б.Отгон (PhD)-ны удирдсан “The major project of China’s National Social Science Fund: Translation and Comparative Study of Catalogues of the Mongolian Documents in Russian Collections (Project No.18ZDA323)” төслийн хүрээнд Македоны Александр III (Аугаа Александр, НТӨ 365-323)-т холбогдох сурвалжууд болон баримт сэлтийн талаар дорно дахины судлаач, түүхч, Британийн эрдэмтэн JOHN ANDREW BOYLE (1916-1978)-ийн бичсэн эрдэм шинжилгээний өгүүлүүдийг орчуулан, зохиогчийн бичсэн он цагийн дарааллаар цуврал болгон хүргэж байгаагийн гурав дахь өгүүлэл болно. Мөн “Монгол судлал” сэтгүүлийн өмнөх дугаар буюу Боть XLVI (587)-д хэвлэгдсэн “Төв Азид дэлгэрсэн Александрын домог” өгүүллийн орчуулгад гурван зүйлийн андуурал гарсан тул хүлцэл өчихийн ялдамд энд залруулж байна. Үүнд: 1. “... асуун шалгааж, олон зүйлийг мэдэж авав. Тэндхийн иргэд ууланд нүхэн гэр (буюу өрх) барин суух агаад олзлогдсон эрээр тэрхүү хоригдол эмийг харгалзуулан, “тэндээс гарч бослого тэмцэлд оролцох санаа бий” эсэхийг асуулахаар илгээж буй нь тэр аж.” гэдэг өгүүлбэрийг “... асуун шалгааж, тэндэхийн иргэд ууланд нүхэн гэр (буюу өрх) барьж суудаг талаар олон зүйлийг мэдэж аваад, “тэндээсээ гарч дайтах санаа бий эсэхийг асуулахаар эмийг нь дэргэдээ олзлон авч үлдээд, мөнөөх эрийг илгээв” (204-205-р тал); 2. “дайснууд” гэснийг “цэргүүд” (205-р тал); 3. “сайн чанарын мод ...” гэснийг “их хэмжээний мод...” (206-р тал).

² Эл өгүүллийг орчуулах явцад хийсэн тэмдэглэгээний талаар энд товч тайлбарлая. Үүнд: 1. Сэтгүүлийн техникийн шаардлагад нийцүүлэн уг өгүүллийн зохиогчийн зүгээс тухайн бичвэрт холбогдох зүүлт, тайлбар хийснийг бүхэлд нь тод хэлбэр (bold)-ээр онцгойлон ялгаж, харин орчуулагчийн зүгээс хийсэн тайлбар (монгол, англи)-ыг үндсэн хэлбэр (regular)-ээр бичив; 2. Оноосон нэр тус бүрийг галиглахдаа тухайн нэрийн холбогдох цахим бичвэрт тэмдэглэсэн дуудлагыг баримталсан бөгөөд ард нь хаалт “()”-ны дотор уг эхийг хадгалах үүднээс өгүүлэл дэх тухайн оноосон нэрийн язгуур хэлбэрийг хэвээр нь бичиж, зарим нэр хийгээд хэрэг явдлын талаар дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүссэн судлаачид, уншигчдад зориулан хөл тэмдэглэгээг давхар хийж, холбогдох цахим хаяг болон бусад эх сурвалжийг оруулав; 3. Зарим эх сурвалж буюу зохиолын нэрийг орчуулснаас гадна уг өгүүллийн зохиогч үсгийн налуу хэлбэрээр ялган тэмдэглэсэн хийгээд оноосон нэр болон зарим тодотгол зэргийг том үсгээр тэмдэглэсэн, мөн түүнчлэн догол мөр, хоосон зай үлдээсэн зэргийг тус тус хэвээр нь үлдээв.

³ Budge, 107-117-р тал, Ryssel, 369-378-р тал. Nödeke (11-17-р тал)-ийн тодорхойлсноор энэхүү Сири эхийг НТ 7-р зууны эхэн хагаст бичихдээ Палавийн эх (Pahlavi original)-д тулгуурлажээ. Би үүнийг Budge-ийн хувилбараас эш татсан бөгөөд түүний галиглан буулгасныг хэвээр үлдээв.

улс (the great kingdom of Maghada)-аас аяллаа эхлүүлж, Дорно зүг зорчив. Тэрээр үнэн хэрэгтээ тэр нутгийн барааг нь харж, нэрийг нь сонсож байсан удаагүй ажээ⁴. Арав хоногийн дараа нэгэн өндөр ууланд хүрэв. Тэр ууланд “лууны дүртэй нэгэн агуу бурхан” залрах агаад тэр нутгийг довтлон ирэх дайснуудаас хамгаалдаг хэмээн нутгийн ардаас сонсов. Бурхан бээр тэрхүү уулыг давахад нь Александрт бэрхшээлийг үл амсуулжээ. Александр арга мэх сийлэн мөнөөх аварга том амьтныг дараад⁵ аяллаа цааш үргэлжлүүлж, өөр нэг өндөр ууланд хүрэв. Тэр уулсын дунд Оксус (Oxus)⁶ мөрөн эх авдаг Барсатис (Barsâtîs) нэртэй гол урсах агаад хожмоо Бирсатос (Bîrsâtôs), Бартеситос (Bartêsîtôs)⁷ гэх нэртэй болжээ. Тэрээр тэндээ нэгэн хотыг байгуулсан бөгөөд тэр хотоо одоогийн Афганистаны нутгаар урсдаг Панжир (Panjshir), Горбанд (Ghorband) нэртэй хоёр голын бэлчирт орших Кавказын Александрия (байж болох юм) “уулын хатан Александрия”-ийн нэрээр нэрлэхээр зарлигдав⁸. Мөнөөх уулнаа залрах бурхдын зөвлөсөн ёсоор, Александр тэндээ цэргүүдээ үлдээгээд дотны гэсэн хорин нөхрөө бараа болгон цааш дагуулж явахдаа “бурхдын хүү болох нэгэн хаантай уулзана” гэж тэдэнд амласан бөгөөд “бурхдын нутгаас эрхэм нэгэн санваартан гарч олон газраар зорчив”⁹ хэмээснээс үзвэл тэрхүү бурхдын хүү гэдэг нь Хятадын Эзэн хаан болж таарч байгаа юм. Тэд эхлээд Катон (Kâtôn (Budge, Ryssel нар өөр байр суурьтай байдаг)) хэмээх нэртэй нэгэн газар хүрэв. Тэр газарт Хитай (Qitai) буюу Хитан (Qitan)-тай холбоотой зүйл байсангүй¹⁰. Тэндээс цааш “өндөр уулыг давж, өргөн мөрнийг гаталж” явсаар бүтэн арав хоног өнгөрөв. Дараа нь элсэн цөлөөр арван таван хоног явж байж, сая нэг Хятад (буюу Sin)-ын захад хүрэв. Тэр газраа Александр өөртөө Питаос (Pîthâôs)¹¹ хэмээх нэрийг өгч¹², өөрийнхөө (Александрыг хэлж буй) элчин хэмээн өөрийгөө танилцуулж, Эзэн

⁴ Tarn, 275-276-р тал, мөн 281-283-р тал.

⁵ Түүнд шохой, давирхай, хар тугалга, хүхрээр дүүргэсэн хоёр үхрийн шир байсан бөгөөд тэрхүү аварга том амьтан тэдгээрийг бүхлээр нь залгичлав. Тэрээр “дархны тулман хөөргийг авчирч, гуулин бөмбөлгийг галд халаагаад, тэр аварга том амьтны аманд цутгахыг тушаав. Тэд галтай бөмбөлгүүдийг аманд нь цутгахад мөнөөх аварга амьтан амаа хамхиад, удалгүй үхэв”. Budge, 108-р тал, Ryssel, 371-р тал. Nöldeke (22-р тал)-д тайлбарлажээ. Уг зохиол давирхай, өөх, үс ноос дүүрсэн булдруутай нэгэн лууг Даниел хөнөөсөн үлгэрийг санагдуулах агаад “Сапор хааны могой (the snake of King Sapor)”-н тухай Ерусалим Талмуд (Jerusalem Talmud)-д гардаг үлгэртэй адил аж.

⁶ Одоогийн Аму Дария мөрний эртний нэршил. <https://www.ancient.eu/Oxus/>

⁷ Budge, 108, 110, 115-р талууд. Эдгээр өгүүлбэрийн төгсгөлд дурдсан энэхүү нэрийг Оксус (Oxus) мөрний Дундад зууны Перс нэр болох Верот (Vehrôt) буюу Берот (Behrôt) гэж ойлгож болно. Барсатис (Barsâtîs) зэрэг нэрийн хувьд, Nöldeke (15, 22-р талууд) Дорныхон төдийлөн мэдэхгүй Бористенис (Borysthenes) гэх нэрийн галигуудыг судалж, тохиолдсон газар бүрт грек эхийн хамт тайлбарлан оруулав. Оксус (Oxus)-ыг тодорхойлохын тулд Днепр (Dnieper)-ийн сонгодог нэрийн хэрэглээтэй, Жаксартис (Jaxartes)-ийг тодорхойлохын тулд Танаис (Tanais (одоогийн Дон)) гэх нэрийн ойролцоо хэрэглээг харьцуулжээ. Tarn, 7-10-р тал.

⁸ Tarn, 246-р тал

⁹ Budge, 109-р тал, Ryssel, 371-р тал

¹⁰ Budge, 109-р тал, 1-р зүүлт, Ryssel, 371-р тал. Монголын байлдан дагууллын үед энэхүү нэр анх Европод танил болжээ. Харин Вэй эзэнт гүрэн (Wei Dynasty (386-556)) түүхийн тавцанд гарч ирэхээс өмнө Хятад даяар төдийлөн мэддэггүй байлаа. Polo I, 216, 218-р талуудыг үзнэ үү.

¹¹ <http://www.attalus.org/translate/alexander3b.html> -ээс дэлгэрэнгүйг үзнэ үү.

¹² Budge (109-р тал, 2-р зүүлт) Πυθίας эс бөгөөс Πόθιος гэсэн асуулт (Nöldeke, 40-р тал, 4-р зүүлтийг үзнэ үү)-аар санал дэвшүүлэв. Энэ бол Александрын Тууж (боловсролгүй, мэдлэггүй эр)-ийн зохиогч өөрийн баатраа туришуулын дүрд хувилган, дайсны хүрээнд оруулахын тулд хэрэглэсэн гол зэвсэг байлаа. Merkelbach, 56, 57, 93-р талууд. Тэрээр Дариус (Darius) болон Кандакэ (Candace)-н үйл хэрэгт Александр анх хэрхэн хандсан талаар бодож сууна. Уг өгүүлбэрт энэ мэт “ухаан муутай, зохисгүй” зүйлийг хэрэглэх нь магадгүй эхэд хэтэрхий халдаж буй хэрэг болно.

хааны Гундафар (Gundâphâr-ын Иран нэрийг авсан)¹³ нэртэй нэгэн жанжинтай урьдчилан хэлэлцсэний эцэст Эзэн хаанд бараалхсан ч авчирсан бэлэг сэлтийнх нь хамт түүнийг буцаажээ. Тэндээсээ Александр Кавказын Александрия хотод “цэргүүд дээрээ ирээд” цааш аяллаа үргэлжлүүлэн, уул давж, арван хоёр хоног явж байж цөлд хүрч, тэр газраа гөрөөстэй адил ч толгой, шүд нь өөр, үнэг мэт, сүрэглэн яваа зэрлэг амьтадтай таарав¹⁴. Тэд бас “хэвлийнээсээ заар гаргадаг амьтад”-ыг олж үзэв¹⁵. Тэр цөлөөс алсад “зэрлэг, бүдүүлэг иргэд”-ийн отогтой таарч, тэдэн рүү довтлов. Александр удирдагчийг нь хороосноор тэдгээр иргэн зугтан одов. Тэрээр цэргүүдийн хамт зэргэлдээх Себазаз (Sēbâzâz)¹⁶ улсад ирэв. Тэндхийн ард иргэд санваартануудын хамт “өргөл барьц, амтлагч ногоо” тэргүүтнийг барьсаар хүрч ирэв. Тэндээ буугаад арав хоног өнгөрсний дараагаар өргөл барьцаа өргөхийг тэдгээр санваартанд зарлигдав. Дараа нь тэр газраас цэргүүдийнхээ хамтаар гарч, Согд (Sogdiana (Sôd)) хэмээх газар хүрэлцэн ирэв. Тэнд “гатлахад нэн бэрх нэгэн их мөрөн баруун өмнө зүгт урсана. Тэр мөрнийг гатлах ямар ч тоног хэрэгсэл үгүй аж”. Александр бурхдад нь өргөл барьж, цэргүүдийнхээ хамт тэр их мөрнийг гатлахад өөрт нь туслах аваас тэндээс зайтай газар нэгэн хот босгож, дотор нь сүм барьж өгнө хэмээн тангараглав. Гатлахуйя бэрх тэр мөрөн гэдэг нь Жаксартис (the Jaxartes)¹⁷ байх магадлал туйлын өндөр юм. Маркварт (Markwart)¹⁸-ын тодорхойлсончлон¹⁹ эл мөрнийг Зарафшан (Zarafshan) гэж эндүүрдэг бөгөөд хэрвээ тэр мөрөн Зарафшан байсан бол тийм хэмжээний саад тогтор учруулахгүй байх байлаа. Гэхдээ тэр их мөрнийг гаталсан гэх мэдээ сэлт тэмдэглэгдэж үлдсэнгүй харин нэг хотыг эзэлсэн тухай баримт бий. Мөн түүнчлэн түүнийг Согдод ирж, Самарканд (Samarqand) хот (энэ нь угтаа түүний бүтээн байгуулсан үйл хэргийн нэг бас биш юм.)²⁰-ыг байгуулж, бас тэрхүү хотын дотор “Нани (Nānî)²¹ хэмээн хүмүүсийн дууддаг” Риа (Rhea)-д

¹³ НТ-ын эхээр Зүүн Персийг захирч асан ийм нэртэй Партиан (Parthian) Эзэнт Гүрний хааны талаар Christensen, 26-27-р талаас үзнэ үү.

¹⁴ Budge, 113-р тал, Ryssel, 374-р тал.

¹⁵ Дурдсан зохиол. Энд “desert” буюу “элсэн цөл” гэсэн нь Арабын түүхчдийн онцгойлон тэмдэглэсэнчлэн Төвөдийн нутгийг хэлж буй. Nöldeke, 46-р тал, 6-р зүүлтийг үзнэ үү.

¹⁶ Энэ нь Nöldeke-ийн Саганиан (Saghānyān)-тай урьдчилсан байдлаар адилтгаж үзсэн (51-р тал, 2-р зүүлт) Арабын Саганиан (Saghānyān), Персийн Чаганиан (Chaghānyān), мөн Шахнама-ийн Чагван (Chagvān of the Chāhpnāma)-тай тохирдог хэлбэрээс гажууджээ. Чаганианы тухайд одоогийн Узбекистаны Термез (Termez)-ийн хойд талын нэгэн дүүрэг юм. Үүнийг EI-д хэвлэгдсэн Bertold Spuler-ийн SAGHĀNYĀN өгүүлээс үзнэ үү.

¹⁷ Одоогийн Сырдария мөрний эртний нэршил. <https://www.thefreedictionary.com/Jaxartes+river>; <https://encyclopedia.thefreedictionary.com/Jaxartes>

¹⁸ Markwart, Josef (1864-1930). Германы түүхч, дорно дахин судлаач, түүхэн газарзүйн мэргэжилтэн. <http://www.iranicaonline.org/articles/markwart-josef>

¹⁹ 153-р тал

²⁰ Александрын бүтээн байгуулалтад (Александрын) Туужийн Сири хувилбар (Budge, 246-р тал) нь “Согд улсын Александрия буюу Самарканд” гэж тэмдэглэсэн боловч Тарн (Tarn) (235, 244, 258-р талууд)-аас үзэхэд үүнийг Александрия-Тирмидт (Alexandria-Tirmidh) гэж андуурчээ.

²¹ Индо-Скиф (Indo-Scythian)-ийн зоосон дээр дүрслэгдсэн Ираны бус гаралтай охин Тэнгэр Нана (Nana) буюу Нанай (Nanai)-ийн талаар Christensen (152-р тал)-ээс үзнэ үү. Армений дуганд Нанай (Nanai (or Nane)) нь Артимис (Artemis)-д, (Agathangelos) нь Амен (Athene)-д шингээжээ. Rene Grousset, *Histoire de l'Arménie des origines a 1071* (1071 он хүртлэх Армений эртний түүх) (Paris, 1974, 120-р тал); A. Carriere, *Les Huit sanctuaires de l'Arménie payenne Agathange et Moïse de Khoren* (Олон бурхан бишрэгч Армений найман шүтээний тухай Агантигелос, Хоренацийн Мовсес (Mose) нарын эргэцүүлэл) (Paris, 1899, 19-р тал)-аас үзнэ үү.

зориулан нэгэн сүм барьж өгсөн тухай тэмдэглэжээ. Александр цэргүүдийнхээ хамт Самаркандаас гарч, дараа нь Бартеситос (Bartêsîtôs) буюу Оксус (Oxus) мөрөнд тулж ирээд, Хефаитион (Hephaestion)²²-ны барьсан хөвөгч гүүрээр мөрнийг гаталжээ. Тэндээсээ цааш хоёр хоног яваад “их урсацтай мөрөн, дараа нь суурин газар олонтой жижиг хотуудаар аялав. Байшингууд нь мөрнөөс холгүй байрлах агаад, иргэд нь энгийн сайхан зантай, газар нь үр тариа ихтэй, буудай жимс арвинтай ажээ”²³. Тэд тэндээ таван сар сууж, дараа нь нэг хот босгож өгөх зарлиг буулган, Перс хэлэнд Бели (Persian Behli) буюу Александрия-Бактра ((Alexandria-Bactra) (хожмоо Балха (Balkh) болсон)) гэж дуудах болсон “Гушийн нутаг” гэх нэрийг тэрхүү хотод өгөв. Тэндээсээ Мургаб (Murghab) нэртэй голд хүрч ирэв. Тэдэн рүү “Париог (Paryôg) ...²⁴ болон түүний бүлэг дайрав”. Александр тэдний мөрийг мөшгөн цааш явж, хэрвээ тэднийг хөөж гүйцэх аваас Аммон бурханд өөрийнх нь нэрээр нэрлэсэн нэгэн хот босгож, түүний дотор өөрт нь зориулан сүм босгож өгье хэмээн тангараг өргөв. Париог (Paryôg) ялагдаж, хороогдсон учир Александр тэндээ хэлсэн ёсоор хот босгож, түүнийгээ “Маргиос (Margiôs (Mârô))”... буюу Александрия-Мерв (Alexandria-Merv) хэмээн нэрийдэв²⁵. Этиопын Хатан хаан Кандаке (Candace)-д бараалхсан тухай өгүүлэх Грек эх (Greek text)²⁶-д бичсэнээр тэд тэндээсээ буцаж, Перс хүрээд, цааш аяллаа үргэлжлүүлжээ.

Энэ бүх үйл явдал Грек эхийн шинэчилсэн хувилбарт байхгүй ч, Грек уг эх (original)-д тулгуурлан бичсэнийг бүхэлд нь давтжээ²⁷. Энэ нь Сири хувилбараас алдагдсан Араб орчуулга (lost Arabic translation)-д, тэндээсээ дахин Арабын түүхчид²⁸-ийн зохиол болон Фирдосийн Шах-нама (Shāh-nāma of Firdausī)²⁹-д

²² Зөв дуудлагыг Markwart (154-р тал), болон 2-р зүүлтээс харна уу.

²³ Budge, 116-р тал, Ryssel, 377-р тал. Балх (Balkh) орчмын нутгийг маш тодорхой, ойлгомжтойгоор тайлбарлахыг зорьжээ.

²⁴ Энэхүү орхигдсон үгийг Nöldeke “марзбан (marzbān) буюу the margrave” (16-р тал, 4-р зүүлт); харин Markwart “балихава (Balhīqavā) буюу the Bactrian” (144-р тал) гэж тус тус уншиж, тайлжээ. Кушан (Kushan)-ны толгойлогч Париог (Paryōgh)-ийн тухай Christensen (441-р тал) болон Éranšahr (65-р тал)-аас үзэж болно.

²⁵ Alexandria-Merv (Александрия-Мерв) буюу (Alexandria in Margiane (Марianaдахь Александрия))-ийн оршин буй эсэх нь үргэлж эргэлзээ дагуулдаг. Tarn, 234-235 болон 246-247-р талуудыг тус тус үзнэ үү.

²⁶ Александрын Тууж (Alexander Romance)-ын хамгийн эртний хувилбар Грек хэлээр бичигдсэн хэмээсэн ч Латин хэлнээ орчуулсан Грек эхийг анхны уг эх (original) гэж үзэхэд нэн эргэлзээтэй гэдэг. Мөн түүнчлэн англи хэлний “text” гэх үгийг монгол хэлнээ “бичвэр, текст, эх бичиг, эх зохиол” (Oxford-Monsudar English-Mongolian dictionary, 2004); “бичвэр, эх сурвалж, жинхэнэ бичвэр” (Чинбат Э, 2001) гэх мэтээр оноожээ. Дээр дурдсан бүхнийг үндэслэн эл үгийг “анхны уг эх”-ээс ялгахын тулд ийнхүү “Грек эх” хэмээн орчуулав.

²⁷ Nöldeke, 22-р тал; Merkelbach, 106-р тал.

²⁸ Nöldeke, 40, 46-р талууд, 8-р зүүлт.

²⁹ Nöldeke, 51-р тал.

шингэжээ. Мөн түүнчлэн энэ нь Кашгар (Kāshgarī)³⁰, Гардизи (Gardīzī)³¹ нарын бичиж үлдээсэн, Түрэгүүдийн дунд өнгөрөөсөн Александрын тухай өгүүлэх тодорхой хэдэн түүхийг бичихэд гол суурь нь болж өгсөн юм. Хятад явах замдаа Александр Түрэгүүдтэй халз тулахаас өөр аргагүй байдалд орсон байх гэсэн саналтай тэрхүү нэр нь үл мэдэгдэх зохиогч санал нийлээгүй гэж хэлэх үндэстэй юм.

“Öge”³² хэмээх үгийн тайлбарт Кашгар эл нэрийн уг гарвалын талаар нэгэн үлгэр (story)³³ ярьж өгөв. Дулхарнайн (Dhu‘l-Qarnain)³⁴-ыг Хятадад орж ирэхэд өөдөөс нь Түрэгийн эзэн хаан хэдэн цэрэг илгээсэн нь цөм идэр залуу эрчүүд байлаа. Гэтэл хааны шадар (vizier)³⁵ хаандаа хандаж өгүүлрүүн: “Та Дулхарнайны өөдөөс идэр залуу эрчүүдээ илгээж байна. Тэдний дунд дайн байлдааны туршлага хуримтлуулсан, нас ахимаг, хашир хүн байх нь зүйд нийцнэ буй за.” хэмээхэд хаан “öge?” гэж асууруун. Өөрөөр хэлбэл “Хашир туршлагатай, нас бие гүйцсэн эр ээ?” гэхэд “Тийм ээ,” хэмээн мөнөөх шадар хариулав. Түүний дараа хаан хашир туршлагатай, бяраа чадал тэгширсэн хүнийг илгээж, тэдгээр цэрэг шөнө дүлээр дайрахад Дулхарнайны нөхөд тулаанаас зугтав. Тэдгээр Түрэг иргэдийн нэг нь Дулхарнайны нэг цэргийг сэлмээрээ цавчиж, хүйс хүртэл нь ярав. Амиа алдсан тэр эрийн бүсэндээ зүүж явсан хэтэвч дүүрэн динартай байсан бөгөөд тэр нь зүсэгдэж, доторх динарууд цустай нь холилджээ. Маргааш өглөө болоход Түрэгийн цэргүүд цусанд будагдсан динаруудыг хараад юу болохыг биенээсээ асуув. Хариулт нь “Алтан хан (Altun qan)” буюу “Алт, цус (Gold and blood)” байлаа. Тэр цагаас хойш тэр нутгийн нэгэн өндөр уулыг энэ нэрээр нэрлэж, тийнхүү Кашгарын үед Уйгур улс (Uighur country)³⁶-ын ойрхон байх тэр уул орчмоор нүүдэлчид нутаглах болжээ. Энэ явдлаас хойш Дулхарнайн Түрэгүүдийг түвшитгэсэн гэдэг.

³⁰ *Кашгар (Kāshgarī)-ийн Dīwān lughat al-Turk (буюу Диван лугат ал-Турк (Турк хэлний толь бичгийн цоморлог))-ийн он цагийг Turcs de l'Asie Centrale, 74-р тал болон Bazin (1957)-ийг үзнэ үү. Bazin (24-25-р тал) “Энэ зохиолыг дараалан дөрвөн удаа буюу эхнийх нь 1072 онд, сүүлийнх (өдгөө бидний үед уламжлагдан ирсэн цорын ганц гар бичмэл) нь 1083 онд засварлажээ” хэмээн дүгнэжээ. [Мөн түүнчлэн Александрын Кашгарт байсан түүхийг Albert Dankoff “The Alexander romance in the Dīwān Lughāt al-Turk (Турк хэлний толь бичгийн цоморлог)”, Humaniora Islamica I (1973), 233-244-р талаас үзнэ үү. Эл өгүүллийг бичиж байх үедээ миний бие Профессор Dankoff-ийн өгүүллийн талаар сонсоогүй нь нэн харамсалтайяа.*

³¹ *Ghazna-д бичигдсэн Gardīsī-ийн Zain al-akhbār-ын талаар Marvazī (Газнад бичигдсэн Гардисын Зейн ал-Ахбар), 10-р талыг үзнэ үү.*

³² *Atalay, I, 90-91-р тал. Öge-ийн тухай Clauson, 1972, 101-р талаас үзнэ үү.*

³³ *Англи хэлний “story” гэх үгийг “1. Олон түмэнд танилцуулах зорилготойгоор зохиогч, өгүүлэгчийн хийсэн элдэв үйл явдал хийгээд хүмүүсийн тухай тодорхойлолт; 2. Хэн нэгэнд юу тохиолдсон тухай яриа; 3. Өнгөсөнд болсон үйл явдал хийгээд хэрхэн өрнөсөн тухай хэрэг явдал; 4. ... ; 5. ” (Oxford Advanced Learner’s Dictionary, 2010) хэмээн тайлбарлажээ. Харин монгол хэлнээ “1. Явдал, хэрэг явдал; 2. Өгүүлэг, хүүрнэл, үлгэр; 3. Өгүүлэл; Зохиомол явдал; 4. Үйл явдал” (Oxford-Monsudar English-Mongolian dictionary, 2004); “1. Өгүүлэг, түүх; 2. ... ; 3. Түүх, үлгэр домог, үлгэр; 4. ... ; 5. Ярьсан зүйл, ам дамжсан яриа” (Чинбат Э, 2001); “1. Үлгэр; 2. Өгүүлэг” (Ганхуяг Ч, 2010) тус тус орчуулжээ. Дээрх тайлбар хийгээд орчуулга, мөн түүнчлэн эл өгүүлэлд дурдагдах “түүх (History)”-ээс ялгахын тулд ийнхүү “үлгэр” хэмээх үгээр буулгав.*

³⁴ *Монголчуудын дунд Сулхарнайн гэх нэрээр алдаршсан бөгөөд “Арабын Цул харнайн буюу Дул харнайн хэмээх уг монгол хэлэнд сунжраад Сулхарнай болжээ. Утга нь хоёр эвэрт хэмээсэн үг. Араб нар Македоны Александрыг чингэж нэрлэдэг байжээ” (Дамдинсүрэн Ц, 2017:180–192).*

³⁵ *Эрт цагт Мусалман шаашинт улс орнуудад байсан өндөр, чухал алба хаадаг хүн (Oxford Advanced Learner’s Dictionary, 2010).*

³⁶ *Эл уулын талаар доорх ...-р хуудаснаас үзнэ үү. Хуудасны дугаар төдийлөн сайн харагдахгүй байна.*

Türkmen³⁷ (буюу Түрэгмэн³⁸) гэх нэрийн талаарх тайлбарт “Түрэгчүүдийн тэр хаан бол Чу (Chu) хэмээх хөндийд байдаг Баласагун (Balasaghun)-д төвлөн суудаг Шу (Shu)³⁹ нэртэй, ид хав нь тэгширсэн нэгэн залуу эр юм” гэжээ. Дулхарнайныг Самаркандаар дайрч, түүний нутаг дэвсгэрт хүрч очиход эрчүүд нь Шу-д хандан Дулхарнай руу дайрах эсэхийг асуув. Тэрээр дөчин туршуулаа Жаксартиз мөрнийг дагуулан тандуулахаар илгээсэн боловч тэд Александрыг тэрхүү мөрөн гаталсан гэх мэдээ авчраагүй учир түүнтэй нүүр тулах айдас үгүй болов. Тэрээр мөнгөөр урласан усны онгоцтой бөгөөд түүнээ аян замд байнга авч явдаг байж. Усаар дүүргэж, дотор нь галуу, нугасыг умбуулан шумбуулна. Эрчүүдийнхээ асуултад хариулахын оронд, тэрээр “Галуу, нугаснууд миний усны онгоцонд шумбаж байгааг хараач” хэмээн дуу алддаг байв. Энэ мэт үгсийг сонссон цэрэг эрсийн урам ихэд хугарч, эзэн нь дайрах хийгээд зугтахын аль ч бодол үгүй олж мэдэв. Ийн зуур, харанхуй бүчин ирэхийн үед туршуулууд нь Дулхарнай мөрнийг гаталлаа гэсэн мэдээтэй ирцгээлээ. Хаан тэр мэдээг сонссон даруйдаа бараа бологчдынхоо хамтаар унаа хөсгөө базааж, Дорно зүг хөдлөв. Гэсэн хэдий ч Синикс (Qīnīq), Салгур (Salghur) болон бусад Огуз аймгуудын өвөг дээдэс болох хорин нэгэн идэр эрс тэр түнэр харанхуйд адуу малаа олж эс чадсан тул тэнд нь үлдээхээс өөр аргагүйд хүрэв. Тэдний арга мухардаж нөхдийнхөө араас явган явах дээрээ тулаад байлаа. Тэр үед гэр бүлээ дагуулан, өөрсдийн гэсэн хөрөнгө хогшлоо үүрч нэлээд ядарсан шинжтэй цувран сажилж яваа хоёр эрийн барааг бүдэг бадаг олж харав. Тэр хоёр эр тэдгээр хорин нэгэн эртэй ярилцаж, цааш явах хэрэгтэй эсэхийг зөвлөлдөхөөр түр амсхийв. Тэд “Дулхарнай зогсолтгүй явж байна, нэг газраа тогтож сууна гэж ер үгүй; таарсан газар бүрдээ зогсолтгүй цааш довтолгоно.” хэмээн хариулжээ. Тэд Түрэг хэлээр “Хал ач! ((Qal ach!)) буюу “Хөөе, эндээ үлдээч” (Hi! Stay!))” гэж хэлжээ. Кашгар (Kāshgharī)-ын өгүүлснээр энэ нь Халач Түрэгүүд (Khalaj Turks)-ийн нэрийн уг гарвал ажээ⁴⁰. Харин одоо Дулхарнай мөнөөх газраа хүрэлцэн ирээд, Түрэгүүдийн бүхий л шинж бүрдсэн тэдгээр эрийг хараад Перс хэлээр “Түрэгман (Turkmān)” буюу “Тэдний төрх Түрэгүүдийнхтэй адилхан”⁴¹ юм байна хэмээн дуу алдсан байдаг. Тиймийн учир тэр цагаас эхлэн тэдгээр эрсийг Түрэгмэн (Türkmen) гэх болжээ. Түрэгийн эзэн хаан цааш Хятад явах зуур Дулхарнай араас нь нэхэн хүрэв. Тэднийг Уйгур улсын захад тулж ирэхийн үед Түрэгийн хаан туршуулаа илгээхэд Александр ч бас хоцорсонгүй. Тэр шөнөдөө хоёр талын туршуулууд хоорондоо тулгарч, Александрын залуус ялагдал хүлээв. Кашгар (Kāshgharī)-ын цаг үед

³⁷ Atalay, III, 412-416-р тал. Minorsky, 1940, 429-р тал.

³⁸ Эл өгүүллийн орчуулгад тэмдэглэгдсэн “Turkish” гэх нэрийг үйл явдал, цаг хугацаа, судалгааны хамрах хүрээг нь үндэслэн “Түрэг” гэж орчуулсан. Эндээс улбаалан “Türkmen” гэх нэрийг “Түрэгмэний угийн бичигт” (Монголын эртний түүх, 2017:11) гэх нэртэй давхиулан “Түрэгмэн” гэж галиглав.

³⁹ Энэхүү “Shu” гэдэг үг нь “Chu”-ийн нэг хувилбар гэж Barthold (*Turcs de l'Asie Centrale* (Азийн Түрэгүүд), 65-р тал)-ийн саналтай зөрөхийн арга бас байхгүй юм. Энэ нь магадгүй Араб бичлэг байж болох юм. *Polo I*, 270-р талыг үзнэ үү.

⁴⁰ Уг нэрийн гарал үүслийн хувьд нийтлэг дагаж мөрддөг хоёр хувилбар байх агаад тэдгээрийг Minorsky, 1940, 428, 430-р талуудаас үзнэ үү. Уг хоёр хувилбарын сүүлийнх (“Stay hungry!”)-ийг Rashīd al-Dīn тэмдэглэжээ. Khetagurov, 85-р тал, Jahn 1969, -р талаас үзнэ үү.

⁴¹ “They are Turk-resembling (Тэд Түрэгүүдийг хураав)” гэсэн үгчилсэн орчуулга.

Алтан хан (Altun Qan)⁴² гэх нэрийг авсан тэр нэгэн уулын ойролцоо хоёр тал эв зүйгээ ололцов. Дулхарнайн Түрэгийн хаантай эвлэрч, Уйгур улсад хэд хэдэн хот суурин барьж өгөөд, тэндээ хэсэг хугацаанд суурьшив. Шу (Shu) нутаг руугаа буцаж, Баласагундаа хүрч ирээд хот барьж түүндээ өөрийнхөө нэр⁴³-ийг өгч, тэндээ нэгэн шүтээн босгох зарлиг буулгав. Тиймээс Кашгар зохиолоо “Тэрхүү хотыг чиглэн нэгэн өрөвтас шувуу нисч ирээд, тэндээ үлдэв” хэмээн төгсгөсөн бөгөөд тэрхүү шүтээний туурь өнөө хэр байдаг аж⁴⁴.

Уйгур⁴⁵-ын талаар бичсэн тайлбарт Түрэгүүдтэй холбоотой өөр хоорондоо зөрүүтэй тайлбарууд байдаг бөгөөд “Уйгур” гэх нэрийн тухайд “Дулхарнайн Түрэгийн хаантай эвлэлдэх үед таван хотыг барьж өгсөн улсын нэр” хэмээн Кашгар тэмдэглэжээ. Мөн тэрээр цааш нь Низам ал-Дин Ибрафил Тоган-Тэгин (Nizām al-Dīn Isrāfīl Toghan-Tegin)⁴⁶-ний эцэг Мухамад Чахир Тонха Хан (Muhammad Chaqir Tonqa Khan)-ны хаанчлалын талаар өөрт нь хүүрнэсэн түүхийг бичиж үлдээжээ. Тухайлбал, Дулхарнайн Уйгур улсад хүрэлцэн ирэхэд Түрэгийн хаган (khaqan) өөдөөс нь малгайдаа шонхор шувууныхтай адил хоёр далавч хадсан дөрвөн мянган цэрэг илгээсэн бөгөөд тэдгээр эрс арагшаа ч урагшаа ч ялгалгүй харвана⁴⁷. Дулхарнайн тэдний тэрхүү чадварыг хараад гайхан биширч, “Эдгээр иргэд хоол хүнсээ өөрсдийн чадлаараа олж иддэг бөгөөд тэдэнд хоол хүнс бэлдэж өгөх хүн хэрэггүй, учир нь тэднээс амьтад зугтаж амжилгүйгээр гарт нь орж, тэд хүссэн цагтаа ангийн мах иддэг юм байна” гэсэн санааг илэрхийлэн “Инан худхуранд (Īnān khudhkhurand)”⁴⁸ хэмээн персээр хэлжээ. Түүнээс үүдэн тэр улсыг Худхур (Khudhkhur) хэмээн нэрлэсэн бөгөөд ха (khā) нь өөрчлөгдөж, алиф (alif) болсон⁴⁹... Энэ талаар Кашгар бичихдээ эл улсад таван хот байх агаад хотын иргэдийн дунд үл итгэгчид хамгийн олон байхаас гадна мэргэн харваачид бий. Эдгээр хотын нэрсийг дурдвал Сулми (Sulmi (Дулхарнайны байгуулсан)), Кочи (Qochi), Жамбалык (Jambaliq), Беш Балык (Besh Baliq), Янгы Балык (Yangi Baliq) аж⁵⁰.

Кашгар Александрын тухай тайлбартаа Чигил (Chigil)⁵¹-ийн тухай бичжээ. Дулхарнайн Аргу улс (Arghu)⁵² буюу Баласагун (Balasaghun), Тараз (Tarāz

⁴² Дээрх ...-р тал, 25-р зүүлтийг үзнэ үү.

⁴³ Өөрөөр хэлбэл Shu юм. *Suyab* гэсэн утгатай байж болно. *Turcs de l'Asie Centrale* (Азийн Түрэгүүд), 65-р талыг үзнэ үү.

⁴⁴ Шүтээний уг чанарын талаар тодорхой судлагдаагүй байгаа нь харамсалтай. Энэхүү шүтээн өрөвтасыг хотоос зайлуулсан уу? Хэрвээ тийм бол, яагаад?

⁴⁵ *Atalay*, I, 111-113-р тал; *Clauson* 1956, 75-р тал.

⁴⁶ Түүний талаар Кашгарын Диван (*Kāshgharī's Dīwān*)-д цорын ганц удаа дурдсанаас мэдээж болно.

⁴⁷ *Esin* 1970, 113-р тал

⁴⁸ “*These are self-eating (khudgkhur)*” буюу “Тэдгээр иргэд хоол хүнсээ өөрсдөө хангадаг” гэсэн үгчилсэн орчуулга. Эл үгийг авиалж буй нь их сонирхолтой. Нэг судлаач *khvadh* (одоогийн *khud*, *khod*) болон *khvar* (одоогийн *khur*, *khor*)-аас үүссэн *khvadhkhvar* гэсэн үгийг өдгөөгийн “to eat (буюу “идэх”)” гэсэн утга бүхий *khvardan* (одоогийн *khurdan*, *khordan*) гэсэн үндэс болно хэмээн тайлбарлажээ.

⁴⁹ Энэхүү үгийг Кашгар (*Kāshgharī*)-ын хэлишинжлэлийн үүднээс сэргээх шаардлагатай эсэхийг бодож байсангүй

⁵⁰ “*Five Towns*”-ны талаар *Hudūd*, 271-273-р талыг үзнэ үү.

⁵¹ *Atalay*, I, 393. Мөн *Hudūd*, 297-300-р талыг үзнэ үү

⁵² Зөвхөн *Kāshgharī*-ийн дурдсан *Arghu*-ийн тухай *Turcs de l'Asie Centrale* (Азийн Түрэгүүд), 66-р талыг үзнэ үү.

(Talas)) хоёрын заагт орших нэгэн газар хүрэлцэн ирэхэд “асар их аадар бууж, зам бүхэлдээ шавар шалбааг болсон тул ихэд ядарчээ. Тиймийн учир тэрээр Перс хэлээр ‘Ин чи гил аст (In chi gil ast)’ буюу “Ямар гээчийн их шавар шалбааг вэ” хэмээн халаглажээ. Тэрээр тэр газар Чигил нэрт хэрэм цайз барихыг цэргүүддээ тушаасан бөгөөд өдгөө ч тэр нэрээрээ бий. Тэнд суурьшсан Түрэгүүдийг энэхүү Чигил гэж нэрлэх болж, энэ нэр хожмоо олон газар түгжээ.

Эцэст нь бид одоо Гардизи (Gardizi)⁵³-ийн хадгалж бичиж үлдээсэн түүх рүү эргэн орёе. Уг түүх бол Иссык Кул (Issyk Kul) нуурын эрэг дээр байх Барсхан (Barskhān)⁵⁴ хотын тухай өгүүлэх юм. Дариус (Darius)-ыг ялсны дараа, Александр тэр газраас гарч явахын цагт зориг сөстэй, авхаалж самбаатай Персүүдийг бослого гаргахаас ихэд эмээж байлаа. Тиймээс Хятад явах замдаа Түркистанаар очих үедээ Персийн харьяат газар бүрээс нэгээс хоёр язгууртан залуу эрхэмийг барьцаа болгон авч явав. Хожим Барсхан (Barskhān) гэх болсон тэрхүү газар хүрч ирээд, байдал төрхийг нь ажиглаж, адуу малд нь хамар хатгах өвс үгүй тийм хүнд хэцүү, эзгүй хоосон газар болохыг олж мэдэв. Тиймийн тул тэрээр илүү ачаагаа тэндээ булж орхиод, мориндоо хоол хүнсийг нь ачих тушаал өгөв. Мөн Хятадаас буцах замдаа Персийн барьцааны иргэдийг аваад нутаг руу нь буцаана хэмээн амлаж, тэднийг үлдэхийг зарлигдав. Гэвч Александр Хятадыг эзлээд цааш Энэтхэг явсан тухай мэдээ ирсний дараа, тэдгээр барьцааны иргэд төрсөн нутагтаа эргэн очих итгэл найдвараа нэгэнтээ алджээ. Александр тэднийг гар урчуудад туслуулахаар Хятад руу илгээж, Перс (Pārs)-ийн хотуудын адил нэгэн хотыг тэнд босгож, Персхан (Pārskhān) буюу “Персийн Хаан (Ruler of Persia)” хэмээн нэрийг өгчээ.

Кашгар Персхан (Barskhān) гэх нэрийн уг гарлын талаар зохиолдоо дурдсангүй. Гэвч түүний өгүүлснээр тэр хотыг Афрасиаб (Afrāsiyāb)-ын хүү буюу уг хотыг үндэслэн байгуулагчийн нэр, эс бөгөөс энэ нутгийг адуу малынхаа бэлчээр болгон сонгож авсан Уйгурын хааны малчны нэрээр нэрлэсэн⁵⁵ аж. Гэхдээ, энэ саналтай бүрэн нийлэхгүй ч Кашгар, Гардизи хоёул олны мэддэг нэгэн сурвалжийг ашигласан гэж үзэхээс өөр арга үгүй юм. Тэр сурвалж нь Александрын Туужийн алдагдсан Араб хувилбарын засварласан Перс эх (a Persian rifacimento)⁵⁶ бөгөөд Гардизийн нэгэн адил тодорхой зохиогч, өөрөөр хэлбэл Ираны ертөнцийн зүүн хязгаарын тухай өгүүлсэн Худуд ал-Алам (Hudūd al-‘Alam)-ыг бичсэн нэр нь үл мэдэгдэх тэр зохиогч бичжээ. Үүний учир энэ нь Түрэг олон аймагтай шууд болон дам холбоотой аж.⁵⁷ Түрэгүүд энэхүү материал (үнэн хэрэгтээ Түрэгийн баатар Алп Тонга (Alp Tonga)-ыг Иранын хаан Афрасиаб (Afrāsiyāb)-тай адилтгаж үзсэн)-ыг яаж ингэж хийж чадав гэдэг асуултад хариулт өгөхүйе бэрх байна. Гэсэн хэдий ч дараа дараачийн судалгаа үүнд бага багаар хариулт өгөх буй за. Энэ зуур, урьдчилсан байдлаар хийсэн энэхүү судалгааг

⁵³ 265-р тал.

⁵⁴ Barskhān (Barsghan)-ны тухай *Hudūd*, 292-293-р талыг үзнэ үү.

⁵⁵ Atalay, III, 417-418-р тал. Эдгээр нь магадгүй Kāshgharī-ийн эцгээсээ сонссон нутгийн уламжлал байж болох юм. Түүний эцэг энэ өгүүлбэрт дурдсанаар бол Barskhān-ны уугуул ажээ.

⁵⁶ Итали гаралтай уг бөгөөд уран зохиол болон хөгжмийн зохиолын тухайн цаг үеийн нөхцөл байдалд нийцүүлэн өөрчилж, засварласан хувилбар. <https://www.merriam-webster.com/dictionary/rifacimento>

⁵⁷ *Turcs de l’Asie Centrale* (Азийн Түрэгүүд), 70-р талыг үзнэ үү.

миний бие өөрийн анд, хамтран зүтгэгч Денис Синортоо зориулж байгаа бөгөөд Төв Азийн өндөр уулсыг давж, өргөн мөрнийг гатлан, хээр талыг хөндлөн гулд явж, Хятадын хил хүрсэн домогт Александрын нэгэн адил түүний судалгааны ажлын зам нь дардан, үржил шимтэй байхын ерөөлийг өргөн дэвшүүлнэм.

Товчилсон нэрийн жагсаалт

Atalay	B. Atalay (орчуулав): <u>Divanü Lûgat-it-Türk Tercümesi</u> (Турк хэлний толь бичгийн цоморлог). 3 Vols. Ankara. 1939-41.
Bazin 1957	Louis Bazin: “Les Dates de redaction du ‘Duvan’ de Kāšgarī (Кашгарын “Диван”-ыг зохиосон огноо)”. <u>AO</u> VII, 21-25.
Budge	E. A. Wallis Budge (хянан шүүж, орчуулав): <u>The History of Alexander, being the Syriac Version of the Pseudo-Callisthenes</u> (Сюдо Келистенийсийн сири хувилбар болон Александрын түүх). Cambridge, 1889.
Christensen	Arthur Christensen: <u>L'Iran sous les Sassanides</u> (Сасанидын эзэнт гүрний үеийн Иран). Copenhagen and Paris, 1936.
Clauson 1956	Gerard Clauson: “A Note on Qarqan (Капканы тухай тэмдэглэл)”. <u>JRAS</u> (1956).
Clauson 1972	Gerard Clauson: <u>An Etymological Dictionary of Pre-Thirteenth Century Turkish</u> (13-р зууны өмнөх үеийн турк хэлний үгийн гарлын толь). Oxford, 1972.
EP ²	Encyclopaedia of Islam (Исламын нэвтэрхий толь). 2 nd ed. Leiden and London, 1960-
Ērānšahr	J. Marquart: <u>Ērānšahr nach der Geographie des Ps. Moses Xorenac'i</u> (Хоренацийн Мовсес (Мосэ)-ийн газарзүйн зургийн дагуух Иран). Berlin. 1901
Esin 1970	Emel Esin: “Bedük Börk”. <u>Proceeding of the IXth Meeting of the Permanent International Altaistic Conference</u> (Олон Улсын Алтай Судлалын Бага Хурлын IX хуралдааны үйл ажиллагаа). Naples, 1970
Gardīzī	<u>Zain al-ankhar</u> . ‘Abd al-Haiy Habībī хянав. Tehren, 1347/1968.
<u>Grundriss</u>	Grundriss der iranischen Philologie. Wilhelm Geiger, Ernst Kuhn нар хянан шүүв. Vol. II. Strassburg, 1896-1904.
<u>Hudūd</u>	Hudūd al-‘Ālam. V. Minorsky хянан найруулж, орчуулав. London, 1937.
Jahn 1969	Karl Jahn (орчуулав): <u>Die Geschichte der Oguzen des Rašīd al-Dīn</u> (Рашид ал-Дины бичсэн Огузын түүх). Vienna, 1969.
Khetagurov	Rašīd al-Dīn: <u>Sbornik letopisei</u> (Судрын Чуулган). Vol. I, Part 1. L. A. Khetagurov. Moscow-Leningrad, 1952.
Markwart	Josef Markwart: <u>Wehrot und Arand</u> (Верот ба Аранд). Leiden, 1938.
<u>Marvazī</u>	V. Minorsky (хянан шүүж, орчуулав): <u>Sharaf al-Zamān Tāhir Marvazī on China, the Turks and India</u> (Шараф ал-Заман Тахир Марвази. Хятад, Түрэг, Энэтхэгийн тухай). London, 1942.
Merkelbach	Reinhold Merkelbach: <u>Die Quellen des griechischen Alexanderromans</u> (Александрын туужийн эх сурвалж). Munich, 1954.
Minorsky 1940	V. Minorsky: “The Turkish Dialect of the Khalaj (Халажын Турк аялгуу)” <u>BSOS</u> XII, 417-437
Mohl	J. Mohl (орчуулав): <u>Le Livre des rois par Abou'l Kasim Firdousi</u> (Абул Касим Фирдусигийн бичсэн хаадын товчоон). 7 Vols. Paris, 1976-78.

Nöldeke	Theodor Nöldeke: “Beiträge zur Geschichte des Alexanderromans (Александрын туужийн түүхэнд оруулсан хувь нэмэр)”. Denkschriften der kaiserlichen Akademie der Wissenschaften. Philosophisch-historische Classe XXXVIII (1890). Abhandlung V.
<u>Polo I</u>	Paul Pelliot: Notes on Marco Polo (Марко Пологийн тэмдэглэл). Vol. I. Paris, 1959.
Ryssel	V.Ryssel (орчуулав): “Die syrische Übersetzung des Pseudo-Callisthenes (Сюүдо Келистенийсийн сири орчуулга)”. Archiv für das Studium der neueren Sprachen und Literaturen XC, 83-133, 269-288, 353-401
Tarn	W.W.Tarn: Alexander the Great (Аугаа Александр). Vol.II. Cambridge, 1948.
<u>Turcs de l’Asie Centrale</u>	W.Barthold: Histoire des Turcs de l’Asie Centrale (Төв Азийн Түрэгүүдийн түүх). Paris, 1945.

Хавсралт

6-р хөл тэмдэглэгээ⁵⁸-д нэмэлт болгов.

Davoud Monchi-Zadeh, Topographisch-historische Studien zum iranischen Nationalepos (Ираны үндэсний баатарлаг туульсын байр зүйн болон түүхийн судалгаа), (Wiesbaden, 1975), Qaton-ыг Khotan-аар таньж ялгах.

Ном зүй

Oxford Advanced Learner’s Dictionary (8th ed). (2010). Oxford University Press.

Oxford-Monsudar English-Mongolian dictionary (1st edition). (2004). Улаанбаатар: Монсудар хэвлэлийн газар.

Ганхуяг.Ч. (2010). *English-Mongolian Dictionary*.

Дамдинсүрэн.Ц. (эмх.) (2017). *Монголын уран зохиолын дээж зуун билиг оривой - Сулхарнайн тууж: Цэндийн Дамдинсүрэнгийн бүтээлийн чуулган*. (Кирилл бичигт хөрвүүлсэн IV боть).

Улаанбаатар: Соёмбо принтинг ХХК

Монголын эртний түүх: Vol. Тавдугаар боть. (2017). МУИС-ийн Монгол Судлалын Хүрээлэн, МУИС-ийн Түүхийн Тэнхим. Улаанбаатар: Соёмбо принтинг ХХК

Чинбат.Э. (2001). *Англи-Монгол толь*. Улаанбаатар: Цээл эрдэнэ ХХК

Цахим эх сурвалж

<https://www.ancient.eu/Oxus/>

<https://www.thefreedictionary.com/Oxus>

<http://www.attalus.org/translate/alexander3b.html>

<https://www.thefreedictionary.com/Jaxartes+river>

<https://encyclopedia.thefreedictionary.com/Jaxartes>

<http://www.iranicaonline.org/articles/markwart-josef>

⁵⁸ Энэ нь эл орчуулгын 10-р хөл тэмдэглэгээ болно.